**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**
**/2022.11.14 - 2022.11.18/**

2022.10.07 Дархан-Уул аймаг

| № | Ажлын чиглэл | Үйл ажиллагааны гүйцэтгэл |
|---|---|---|
| | | **Барилга хот байгуулалтын хэлтэс** |
| 1 | Барилга угсралтын чиглэлээр | ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Дархан сумын 8-р багт "Ти эм ойл" ХХК-ний ШТС зориулалттай барилгад олгосон.<br>✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу Дархан сумын 12-р багт Хүслийн хотхоны 108 айлын 2-р ээлжийн 8-р барилгыг ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан.<br>✓ Дархан-Уул аймгийн хэмжээнд барилгын салбарын инженер техникийн ажилтан, мэргэжилтэн ажилтны судалгааг гаргаж барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.<br>✓ Аймгийн хэмжээнд шинээр баригдаж байгаа орон сууцны дэлгэрэнгүй судалгааг гаргаж байгууллагын вебсайтад байршуулж иргэдэд сурталчилж ажилласан. |
| 2 | Барилгын материал үйлдвэрлэл | ✓ Барилгын хөгжлийн төвөөс батлагдсан №66/22 тоот удирдамжаар "**Идэрхайрхан"** ХХК-ний Дархан Уул аймаг, Хонгор сум, 1-р баг, /4502007595/ 30.8 га талбай бүхий уурхайн зориулалттай газар **чулуу бутлан ангилах** үйлдвэртэй очиж танилцан үнэлгээг шалгах хуудсаар бүртгэн үйлдвэрийн талбайд очиж үнэлгээг хийж ажилласан 2022.11.21<br>✓ Эрсдэлтэй барилгын судалгааны дагуу ажлын хэсэгт ажилласан. Дархан сумын Нийтийн зориулалттай орон сууцны барилгын орцны хэсэгт эрсдэл үүссэн эсэхэд хяналт шалгалтаар явсан. |
| | | **Газрын удирдлагын хэлтэс** |
| 1 | Суурь судалгаа, газрын мониторинг | ➢ Дархан-уул аймгийн хэмжээнд захиалгат хянан баталгааны 2 тайлан баталгаажуулсан. |
| | | **Захиргаа аж ахуйн чиглэл** |
| 1 | Мэдээллийн технологи, нярав | **Мэдээлэл:**<br>70376471 нээлттэй утсаар 2, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 4 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.<br>Монгол бичгийн контентод зориулан албан хаагчдаас монгол бичгийн мэдлэгийн төвшин тогтоох шалгалт авч, бичлэг хийв. Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулав.<br>**Мэдээллийн технологи:**<br>Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл цэсний Газрын харилцаа хэсэгт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээлэл оруулав.<br>Байгууллагын Фэйсбүүк хуудсанд Газрын харилцаа хэсэгт геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай мэдээлэл, Газрын төлөв байдал чанарын хянан баталгааг ямар тохиолдолд хийлгэх тухай мэдээлэл, Дархан-Уул аймгийн Барилгын салбарын спортын их наадмын зар, Сумдын газрын даамлуудад ГЗБТ, кадастр, мониторингийн чиглэлээр сургалт хийсэн тухай мэдээ оруулав.<br>**Нярав:**<br>Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 1 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 5 ширхэгийг хүлээж авч бүртгэв.<br>Шаардах хуудсаар 4 төрлийн 7.5 ширхэг бараа материал олгов. 2022 оны 5-8-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн зарцуулалтын тайланг үдэж, хавтаслан хуудсуудыг дугаарлаж, архивт хүлээлгэн өгөв. |

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга Г.Нямдорж